

Эмэгтэйчүүд ба Хөгжил

А. Солонго

Хүн Ам Зүйн Сургалт

Судалгааны Төвийн багш

Цуврал лекц-2

Хүйсийн шинжилгээний хүрээ

Өмнөх лекцээрээ (цуврал-1) бид Хүн Ам Зүйн шинжлэх ухаанд хүйсийн асуудлыг хэрхэн авч үздэг талаар ойлголт, тодорхойлолтуудтай танилцсан билээ. Энэ удаагийнхаа лекцээр хүйсийн судалгаа, шинжилгээний хүрээ гэж чухам юу юм, уг хүрээ нь ямар ач холбогдолтой болохыг авч үзэх болно.

Хүйсийн ялгаа (gender) гэдэг нь цаг хугацаа улиран солигдох тутам өөрчлөгдөн байгаа эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн нийгэмд гүйцэтгэх үүргээр илэрхийлдэнэ. Иймд хүйсийн ялгаа, эрх тэгш байдлыг тусгаагүй аливаа төсөл үр дүн багатай болж улмаар эмэгтэйчүүдийн эрх тэгш байдалд сөрөг нөлөө үзүүлдэг байна. Хүн амын онцгой хэсэг болох эмэгтэйчүүдийн хувьд авч судалбал зохих эдийн засгийн болон хүн ам зүйн асуудлууд нь нийгмийн олон талт амьдралд асар их нөлөөлдөг эмзэг шинжтэй байдгаараа онцлог юм.

Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн эрх тэгш байдлыг судлах хүрээг Хардвардын Их сургуулийн эрдэмтэд: Catherine Overholt, Mary B. Anderson, Kathleen Cloud, James Austun нар боловсруулжээ. Судалгааны энэхүү хүрээний гол зорилго нь хөгжлийн аливаа төслүүдэд хүйсийн талаарх асуудлыг хэрхэн тусгах вэ? гэсэн ойлголтыг гүнзгийрүүлэхэд орших бөгөөд уг хүрээ нь хамгийн үр ашигтай төслийн загварын гол хэрэгсэл болж өгдөг.

Хүйсийн (gender) судалгаагаар эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн нийгмийн үүрэг, хариуцлагыг шууд болон шууд бус замаар тодорхойлох ба ингэхдээ үнэн зөв мэдээллийг үндэс болгодог. Түүнчлэн тодорхой төслийн хүрээнд ямар уриан дор үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх вэ? гэдгийг мөн тодорхойлж өгнө.


Хүйсийн судалгааны үед:

а/ хүмүүсийн үйл ажиллагаа тухайлбал хөдөлмөр хуваарилалт

б/ хөрөнгийн бололцоо, тэдгээрийн хуваарилалт, ашиглалт

в/ ёс заншил, нийгэм эдийн засгийн тогтолцоо, хүүхдийн өртөг гэсэн асуудлууд анхаарлын төвд тавигддаг.

Хүйсийн судалгааны хүрээ 3 үндсэн хэсгээс бүрддэг.



– **Үйл ажиллагаа:** Энэ нь судалгааны хүрээний идэвхтэй хэсэг бөгөөд эрэгтэйчүүд эмэгтэйчүүд хэзээ, хаана, чухам юу хийж гүйцэтгэх вэ? гэдгийг тодорхойлдог. Үүн дээр үндэслэн хүн амын хөдөлмөр хуваарилалт, үйлдвэрлэл, нөхөн үйлдвэрлэл дэх үйл ажиллагааг хүйсээр, насаар, нийгмийн анги давхаргаар болон бусад үзүүлэлтээр гаргах шаардлагатай. Түүнчлэн хүн амын гүйцэтгэж буй үйл ажиллагааг цаг хугацаа, байршлаар илэрхийлэх хэрэгтэй.

– **Нөөц бололцоо, хяналтын хэсэг:** Хүмүүст үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах чухам ямар нөөц байна вэ, нөөц ашигласнаар чухам ямар ашиг хүртэх вэ, эдгээр нөөцийг ашиглах, ашиглалтанд хяналт тавихад эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн оролцоо ямар байна вэ, гэдгийг энд тодорхойлдог. Цаашилбал хяналтыг хэн тавих вэ гэсэн асуудал гарч ирнэ. **Нөөц** гэдэгт ажил, цаг хугацаа, хөрөнгө, газар, боловсрол, сургалт, мэдлэг зэргийг, **ашиг** гэдэгт орлого, хүнс, эрүүл мэндийн талаархи хангамж, боловсрол, мэргэшил зэргийг хамруулна.

– **Хүчин зүйлүүд:** Хүчин зүйлүүдийг дараахи байдлаар ангилж үздэг. Үүнд:

Нийгмийн хүчин зүйлүүд: нийгмийн нормууд, уламжлалт ёс заншил, шашин шүтлэг, нийгмийн тогтолцоо

Эдийн засгийн хүчин зүйлүүд: эдийн засгийн тогтолцоо, ядуурлын түвшин, инфляцийн түвшин, дэд бүтцийн хөгжил, газар хуваарилалт-зохион байгуулалт, хүрээлэн буй байгаль орчны байдал

Улс төрийн хүчин зүйлүүд: засаглал, засгийн газрын хүнд суртал, хуулийн тогтолцоо, хамтын шийдвэр гаргах тогтолцоо

Хүн ам зүйн хүчин зүйлүүд: дундаж наслалт, нялхсын нас баралт, эхийн эндэгдэл, шилжих хөдөлгөөн гэх мэт

Тэгэхлээр хэрэгжүүлэх аливаа төслийн үр дүн, ашиг нь хүмүүсийн үйл ажиллагаа, тэд цаг хугацааг хаана, хэрхэн өнгөрөөв, нөөцийг яаж ашиглав, тэдний аж байдал, түүний хамгаалалт хэрхэн шийдэгдэв гэдгээс шалтгаална. Энэ бүхэн нь чухам ямар шийдвэр гаргасан, гаргасан шийдвэрээ хэрэгжүүлэх үүднээс төсөл, хөтөлбөрийн ажилд хэрхэн оролцсон зэргээс хамаардаг. Иймд хүйсийн ялгааг судлах аливаа төслийн загвар гаргах, түүнийг хэрэгжүүлэхэд дээр дурдсан бүрэлдэхүүн хэсгүүдийг анхаарах нь чухал юм. Аливаа шийдвэр тухайлбал төрөлтийн шийдвэр нь гэр бүл төлөвлөлт, хүн амын төслийн хүрээнд шийдвэрлэгдэнэ. Ийм шийдвэр нь нийгэм, эдийн засаг, хүн амын хүчин зүйлүүдээс хамаарна. Эдгээр нь үйл ажиллагаа, бололцоо, хяналтанд мөн л шууд бусаар нөлөөлнө. Хүйсийн ялгааны талаархи судалгаа, шинжилгээ нь дээрх нөлөөллүүдийг хамруулан авч үзэх бөгөөд аливаа төслийн загварыг тодорхойлоход чухал үүрэгтэй.

Үйл ажиллагааны идэвхтэй байдал нь чухам ямар салбарт илүү илэрч байна вэ? гэдгийг авч үзэхдээ бид 2 үндсэн зүйл дээр анхаарах шаардлагатай. Үүнд: үйл ажиллагаа явуулахад *нэгдүгээрт*: Хөрөнгө мөнгө, санхүүгийн байдал, *хоёрдугаарт*: Санхүүгийн эх үүсвэрийг хэрхэн олж авах вэ гэсэн асуудал юуны өмнө тулгардаг. Санхүүгийн эх үүсвэр буюу нөөц олж авахад хүйсийн хувьд тэнцвэрт бус харьцаа ажиглагддаг. Жишээбэл: Өөрийн (хувийн) хөдөлмөр эрхлэх боллоо гэж үзье. Үйл ажиллагаа явуулахад шаардагдах хөрөнгө нь:

а/ Өөрийн хөрөнгө


б/ Зээлийн хөрөнгө үндсэн 2 эх үүсвэртэй байна.

Өөрийн хөрөнгийн асуудал нь эрх зүйн үүднээс бус нийгмийн сэтгэхүйтэй шууд холбоотой байдаг төдийгүй эмэгтэйчүүдэд маш эмзэг тусдаг. Зарим улс оронд ялангуяа хүйсийн ялгаа асар хүчтэй байдаг өөрөөр хэлбэл хүйсийн сонголт ихтэй улс орнуудад (тухайлбал Энэтхэг, Хятад гэх мэт) эхийн хэвлийд байхаасаа л охидууд ялгаварлан гадуурхагдаж эхэлдэг. "Эмэгтэйчүүд төрөхөөс үхэх хүртлээ хүйсээр ялгаварлагддаг". Түүнчлэн олонхи улс үндэстэнд өв залгамжлал хөвгүүдэд давамгайлдаг. Охидоо нөхөрт гарч хүний хүн болдог гэж үзэх үзэл түгээмэл байдаг. Иймээс ихэнх тохиолдолд хувийн өмч нь эрэгтэйчүүдийн мэдэлд байдаг байна.

Ямар нэгэн зээл олгоход хаана ч тэр зээлийн баталгаат байдлыг харгалзаж үздэг. Өөрөөр хэлбэл тухайн зээлдэгч нь үл хөдлөх хөрөнгөтэй байх ёстой. Зээлийн хөрөнгийн ядаж 25 хувьтай тэнцэх өөрийн баталгаат хөрөнгөтэй байх шаардлагатай бөгөөд энэхүү шаардлага нь зээлдэгч илүү их хариуцлагатай байх нөхцлийг бүрдүүлж өгдөг. Иймд зээл ч гэсэн мөн цаана нь баялаг нөөц нь хэр билээ гэдэг баталгааг харгалзан эрэгтэйчүүдэд илүү олгогддог байна. Олонхи оронд эмэгтэйчүүдийн байгууллага, нэгжүүдийн эсэргүүцлээр өмч өвлөх эрхийг тэгш эзэмшихээр хуулиар заасан байдаг боловч бодит амьдрал дээр яг тийм байдаггүй. Монголын өмч хувьчлалын асуудлыг энд жишээгээр авч үзэж болох юм. Манайд ард түмнээ зах зээлд жигд гараанаас гарах зорилгоор улсын (нийтийн) өмчийг

задлаж, өмчийг тодорхой эзэнтэй болгох зорилтыг хэрэгжүүлж эхэлсэн билээ. Мал хувьчлал нь тухайн өрхийн тэргүүний нэр дээр бүртгэгдэж байна. Иймээс түүнийг захиран зарцуулах давуу эрхийг өрхийн тэргүүн эрэгтэйчүүд л эдэлж байх жишээтэй.

Үйл ажиллагаагаа төлөвлөж явуулахын тулд өндөр мэргэжил боловсролтой байх шаардлагатай. Эмэгтэйчүүдийн статусыг тодорхойлдог нийтлэг хэмжүүрийн нэг нь боловсролын янз бүрийн түвшинд тэдний эзлэх хувь юм. Эмэгтэйчүүдийн боловсрол, мэргэжлийн түвшин доогуур байвал сонголт хийх боломжгүй. Иймээс ч дэлхийн олонхи улс оронд үнэлгээ багатай, мэргэжлийн ур чадвар бага шаардсан (асрагч, үйлчлэгч, туслах ажилтан г.м) ажлуудыг эмэгтэйчүүд зонхилон хийж байна. Манай орны хувьд дээд боловсролтой хүн амд эмэгтэйчүүдийн эзлэх хувь хэмжээ харьцангуй өндөр байгаа явдал нийгмийн нэг гаж үзэгдэл болоод байна. Өөрөөр хэлбэл боловсролд хүйсийн тэнцвэрт харьцаа алдагдаж байгаа бөгөөд хэсэг хугацааны дараа энэ байдал нь нийгэмд тодорхой сөрөг нөлөө үзүүлэх аюулд хүргэж болох юм. Дээд боловсролтой 100 эрэгтэй тутамд ногдох эмэгтэйчүүдийн тоог зарим улсуудтай харьцуулсан байдлаар зураг 1.1-д үзүүлэв. Эндээс дээд боловсрол эзэмших талаар Монголын эмэгтэйчүүдийн харьцангуй өндөр түвшинд байгаа нь харагдаж байна.



Гэтэл удирдлага, зохион байгуулалтанд эмэгтэйчүүдийн оролцоо маш доогуур байгаа нь анхаарал татаж байгаа бөгөөд Монголын эмэгтэйчүүдийн боловсролын энэхүү өндөр түвшинг нийгэм эдийн засгийн хөгжилд аль болох бүрэн дүүрэн ашиглах, хүрсэн түвшинг алдахгүй байх явдал төр засгийн өмнө чухлаар тавигдаж байна.

Эдийн засгийн ямарваа нэг өөрчлөлтүүд эмэгтэйчүүдэд илүү тусдаг. Жишээ нь эмэгтэйчүүд зонхилон ажилладаг хөнгөн үйлдвэрт технолгийн шинэчлэлт хийснээр тухайн салбарт ажлын байр хомсдоно. Энэ нь эргээд ажилгүйдэлд эмэгтэйчүүд их өртөнө гэсэн ойлголт гарах үндэс болж байгаа юм. Үйлдвэрлэл, хөгжилд эмэгтэйчүүд ямар хувь нэмэр оруулж байна вэ?

Эдгээр хувь нэмэр нь хэрхэн үнэлэгдэж, хэмжигдэж байна вэ? гэдэг талаас нь судалгааг явуулах нь ач холбогдолтой байх болно. Амьд явах,

санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, сонгох, сонгогдох, өмч хөрөнгө, орон сууц эзэмших, чөлөөтэй шилжин суурьших гэх мэт хүний салшгүй эрхүүд дотроос цалин авах эрх бол нийгмийн өмнө хариуцлага хүлээх чадвар бүхий тухайн хүний эдийн засгийн эрх чөлөөний илэрхийлэл болохын хувьд онцгой чухал асуудал гэдгийг энд анхаарах хэрэгтэй.

Түүнчлэн хүрээлэн байгаа байгаль орчны асуудал хамгийн түрүүнд эмэгтэйчүүдэд тусдаг. Эмэгтэйчүүд байгалийн баялгийг ашиглан гэр бүлийнхээ хоол хүнсийг бэлтгэдэг. Байгаль орчны бохирдолт нь эмэгтэйчүүдийн гэрийн ажилд сөрөг нөлөөтэй. Үүнээс үүдэн түлээ түлш бэлтгэх, ундны ус татах гэх мэт үнэлгээгүй гэрийн ажилд хугацаа их зарцуулах болдог. Гэтэл байгаль орчны асуудлаар шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн үүрэг, роль маш бага байна.

Эмэгтэйчүүдийн нийгмийн статусыг тухайлбал, тухайн улсын соёл иргэншлийн онцлог, төрийн бодлогын шинж чанар, иргэний ардчиллын түвшинг харуулдаг нэг чухал үзүүлэлт нь удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагаанд ялангуяа тэдгээрийн дээд түвшинд эмэгтэйчүүд хэрхэн оролцож байна вэ? гэдгээр тодорхойлогддог. Хүний эрх хуулиар хамгаалагдсан, тэгш боломжийн иргэний нийгэмд нийгмийн амьдралын бүх хүрээнд идэвхтэй үүрэг хүлээх эмэгтэйчүүдийн эрх бололцоог хэн ч албан ёсоор хааж боодоггүй боловч жинхэнэ бодит амьдрал дээр байдал эрс өөр байдаг бөгөөд энэ бүгдийг судалгаа, тоо мэдээллээс л харж болно. "Шийдвэр гаргахад эмэгтэйчүүдийн оролцоо" гэдэг нь нэлээд сүүлд гарч ирсэн тодорхойлолт юм. Удирдан дагуулах, бодлого боловсруулах, шийдвэр гаргахад эмэгтэйчүүдийн оролцоо ямар байна вэ? гэдгийг тодорхойлохын тулд:

а/ Төр засаг, бизнес, удирдлагад хичнээн эмэгтэй ажиллаж байна вэ?
 б/ Уг харьцаа цаашид ямар хандлагатай байх вэ? гэсэн гол үзүүлэлтийг харгалзах хэрэгтэй байдаг. Эмэгтэйчүүдийн төр, улсын удирдах ажилд оролцох оролцоог Олон улсын хэмжээнд авч үзвэл НҮБ-ийн гишүүн орнуудын (1990 оны байдлаар) 3,6 хувь нь эмэгтэй тэргүүнтэй байсан бөгөөд Скандиновын болон Умард Европт энэ үзүүлэлт харьцангуй өндөр байна. Дэлхийн сайд нарын кабинетуудын 10 хувь нь эмэгтэйчүүд бөгөөд дэлхийн 95 оронд эмэгтэй сайд байдаггүй байна. Яамдын түвшингээс дээш албан тушаалд ажилладаг эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жингээр Норвеги, Доминикан, Бутан, Филиппин зэрэг улсууд тэргүүлж байна. Парламентэд эмэгтэйчүүдийн эзлэх хувь хэмжээ зарим оронд буурч байгаа бөгөөд тухайлбал Япон, Уругвай зэргийг дурдаж болно. Шийдвэр гаргах эрх бүхий байгууллагад ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн тоог тодорхойлохдоо олон улсын ба энх тайвны байгууллагад ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн оролцоо гэсэн үзүүлэлтийг авч үздэг. Дэлхийн хэмжээнд Нобелийн шагнал хүртсэн 87 хүний 8 нь эмэгтэйчүүд байна. Эмэгтэйчүүдийн удирдах албанд хэр оролцож байгаагаар тэдний мэргэжил, боловсролын түвшин, нийгэмд эзлэх байр суурь, идэвхийг тодорхойлж болох бөгөөд үнэн зөв дүгнэлт гаргахад мөн л тодорхой тоо мэдээлэл гол үзүүлэлт болно. Эдгээр тоо мэдээлэл нь хөгжилд эмэгтэйчүүдийн оролцоо хэрхэн өөрчлөгдөж байгааг харуулна.

Олон улсын жишигт:

- Төр засгийн удирдах дээд, дунд түвшинд
- Улс төр, Олон нийтийн байгууллагад

– Аж ахуй, бизнесийн үйл ажиллагаанд
– Өрх гэрийн хүрээнд гэсэн чиглэлээр дээрх түвшинг тодорхойлж, үнэлэлт дүгнэлт өгдөг.

Улс орноо удирдахад иргэн бүр оролцох эрхтэй гэдгийг хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан байдаг. Гэтэл дэлхийн ихэнх улс оронд нийгмийг ардчиллах хөдөлгөөн өрнөж байгаа ч олон оронд төрийн удирдлагын ихэнх түвшинд, ялангуяа яамд, гүйцэтгэх засаглалын газруудад эмэгтэйчүүд дутуу төлөөлөлтэй байна. Нийт сонгогчдын бараг тал хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа хэдий ч хууль тогтоох байгууллагын гишүүдийн зөвхөн 10 хувь, сайдын албан тушаалд бүрч бага хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Олон улсын хэмжээнд ихэвчлэн өв залгамжилсан сайд нь эмэгтэй байдаг байна. Бангладеш, Энэтхэг, гэх мэт. Харин онцгой үүрэг гүйцэтгэдэггүй (тухайлбал спортын, соёлын, хүүхэд эмэгтэйчүүдийн), яамдыг эмэгтэйчүүд толгойлдог. Дэлхийн ихэнх улс оронд Сангийн яам, Батлан хамгаалах, Гадаад харилцаа, худалдаа зэрэг гол яамдуудад эмэгтэй сайд байхгүй байна.

Дүгнэлт

Хүчин зүйлүүд, үйл ажиллагаа, нөөц бололцоо, тэдгээрийн хяналтын дагуу хүйсийн ялгааг судлах нь төслийн загварыг тодорхой болгох ач холбогдолтой бөгөөд судалгааны хүрээ нь маш уян хатан байх шаардлагатай. Хөгжлийн талаархи аливаа төсөл, бодлого хөтөлбөрүүдийг санаачлах нь эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн аль алиных нь нийгэмд гүйцэтгэх үүрэг ролийг дээшлүүлж байдаг. Эцэст дүгнэхэд манайд гадаад дотоодын олон арван байгууллагуудын тусламж, зээл, санхүүжилтээр эмэгтэйчүүд төдийгүй нийгмийн эмзэг давхаргуудад чиглэсэн төрөл бүрийн төслүүд хэрэгжүүлж байгаа бөгөөд эдгээр төслийн хөрөнгийг үр дүнтэй, амжилттай, ашигтай байлгахын тулд бид хүйсийн судалгааны хүрээг нарийн авч үзэх, энэ талаар тодорхой ойлголттой болох нь чухал ач холбогдолтой юм.

Ашигласан материал

United Nations Population Fund, "Incorporating Women into Population and Development Knowing Why & Knowing How" New York, 1994

International women's tribune centre, 1994 "A women and Development quarterly"

"Human Development report" 1995

"Demographic Yearbook", 1992

"The World's Women", 1991

"Хүн ам ба Хөгжил дэвшил" НҮБ-ийн Хүн амын сан, 1994 он

"Хүн амын асуудал" НҮБ-ийн Хүн амын сан, 1993 он